

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэргэжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>Стратеги төлөвлөгөөний зорилго: 1</b> Иргэдийн эрүүл, идэвхтэй амьдралын зөв дадал, хэвшлийг дэмжих, нийтийн биеийн тамир, спортын үйлчигээ сайжруулах, хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэн улсын хэмжээнд өрсөлдөх чадвар, амжилтыг ахиулна.							
<b>НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>							
<b>Зорилт 1.1</b>	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас А, В, үнэлгээтэй иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх	ОНТ 3.0 сая	А, В, үнэлгээтэй иргэдийн хувь	24.9	27.9 хувь	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар тогтоолын дагуу Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг хавар, намрын улиралд жилд 2 удаа зохион байгуулж, 15 сумын албан байгууллагын нийт 4580 иргэнийг хамруулсан байна Сорилд хамрагдсан иргэдээс А үнэлгээтэй 1170, В үнэлгээтэй 997 иргэн байгаа нь нийт сорилд хамрагдагсдын 2167 буюу 47,3 хувийг эзэлж байна.	<b>100</b>
1.1.1	Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх нийтийн бие тамир, спортоор тогтмол хичээллүүлэх	ОНТ 2.0 сая	Нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоо	25921	26649	Өглөөний дасгал, алхалт, дугуй, бясалгал, хийн дасгал, зөөлөн гүйлт зэрэг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр нийт 28800 гаруй иргэн тогтмол хичээллэж байна.	<b>100</b>
1.1.2	Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэгчдийн нэмэгдүүлэх дасгал тогтмол тоог	ОНТ 2.0 сая	Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээлл	8039	10230	Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар зохион байгуулагдсан "Илүүдэл жингүй Эртэч монгол" аяны хүрээнд аймгийн хэмжээнд 15 сум, 18 заал, 5 клуб, 9 танхим, 43 байгууллага дээр 10-78 насны давхардсан тоогоор нийт 42268 иргэн нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэсэн.	<b>100</b>

			эгчдийн тоо				
1.1.3	Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах	ОНТ 26.0 Хандив 2.0 сая	Хамтран ажилласан спортодын тоо	13	14	Аймгийн спортын 17 холбоо 8 клубтэй хамтран, улс, бүс, аймгийн аварга шалгаруулах, нэрэмжит зэрэг 80 гаруй уралдаан тэмцээнийг зохион байгуулж, нийт 28500 иргэн оролцсон байна.	100
			Хамтран ажилласан спортох хамтлагийн тоо	29	32	Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 39 байгууллагын спорт хамтлагтай хамтран спортын 36 үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 28500 иргэдийг хамруулсан. Илүүдэл жингүй эртэч монгол аян, бие бялдрын түвшин тогтоох сорил, Гимнастрада, алхах, гүйх, явган аялал зэрэг ажлыг хамтран зохион байгуулсан.	100
1.1.4	“Нээлттэй хаалганы өдөр” – арга хэмжээг зохион байгуулах	УТ 500,0 мянган	Өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо	350	360	Байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөгийг үндэсний сур, шагайн харваа, ширээн шагай, буудлага, бадминтон, дугуй зэрэг спортын сурталчлах өдөр болгон зохион байгуулж явуулсан. Тус арга хэмжээнд тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд болон аж ахуйн нэгж байгууллага, иргэд идэвхтэй оролцож 400 гаруй иргэд хамрагдлаа.	100
1.1.5	Спортын цол зэрэг авсан тамирчдыг биеийн тамир, спортын мэдээллийн санд бүртгэх	0	Мэдээллийн санд бүртгэсэн эсэх /тийм үгүй 1-0/	1		Спортын цол зэргийн болзол хангасан 26 тамирчдын мэдээллийг тухай бүр мэдээллийн санд бүртгээд байна.	100

1.1.6	Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, спорт холбоодод шилжүүлэн хамтран ажиллах гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллах	УТХО 6.0 сая	хамтран ажилласан спорт холбоодын тоо	5	7	Аймгийн болон улсын нийт 17 спорт холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулан улсын болон аймгийн аварга шалгаруулах тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулсан. Мөн улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцох эрхийн төлбөр, байр, хоол, унааны зардал, бэлтгэл сургалт явуулах заал танхимаар ханган үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн.	100
1.1.7	“Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын ач тусыг сурталчлах өдөрлөг зохион байгуулж арга зүйгээр хангах	УТ 2,0 сая	Өдөрлөг зохион байгуулсан сумдын тоо	2	3	Дэлгэрцогт, Гурвансайхан, Дэлгэрхангай суманд бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ийн ач тус сэдэвт өдөрлөг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 3 сумын 600 гаруй иргэд оролцлоо.	100
1.1.8	“Гимнастрада” биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах	ОНТ 1,0 сая	Арга хэмжээнд хамрагдсан сумдын тоо	5	6	Аймгийн хэмжээнд “Гимнастрада” биеийн тамирын арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд 10 сумын төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллага оролцлоо. Идэвхтэй оролцсон сум байгууллагыг спортод ээлтэй сум байгууллагаар шалгаруулсан.	100
1.1.9	Иргэдийг биеийн тамир, спорт, эрүүл амьдралын зан үйлийг төлөвшүүлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	0	Сургалт ад хамрагдсан иргэдийн тоо	200	250	Төрийн тусгай албаны 5 байгууллага төрийн үйлчилгээний 2 байгууллага, төрийн өмчит 3 байгууллага болон 7-р багийн иргэдийн нийтийн хурлын төлөөлөгч 500 гаруй иргэдийг сургалтад хамруулсан	100
1.1.10	“Бүх нийтийн кросс” гүйлт нас насны ангиллаар аймгийн хэмжээнд зохион байгуулах	УТ 3,0 сая	Хамрагдсан иргэдийн тоо	650	700	Бүх нийтийн кросс гүйлтийн тэмцээнийг Биеийн тамир, спортын газрын даргын батлан гаргасан удирдамжийн дагуу 18-24 нас 25-34 нас 35-44 45-50 50 -аас дээш насны ангиллаар аймгийн 15 суманд 2022 оны 06 дугаар сарын 07 ны өдөр нэгэн зэрэг зохион байгуулж дүнг нэгтгэн гаргасан.Тус арга хэмжээнд 15 сумын 1000 гаруй тамирчин оролцон байна.	100

1.1.1 1	Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн нэгдсэн санг баяжуулах	0	Баяжилт хийсэн эсэх /тийм үгүй 1-0/	1	1	2022 онд зохион байгуулагдсан улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээн, аймгийн аварга шалгаруулах тэмцээн, уралдаан ажил арга хэмжээг байгууллагын цахим мэдээллийн санд байршуулан ажилласан.	100
1.1.1 2	“Дасгал хөдөлгөөн, эрүүл мэнд” аяныг аймгийн 15 сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд өрнүүлэх амьдралын эрүүл хэв маяг төлөвшүүлэх	УТ, ОНТ 1.0 сая	Аянд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо	25	30	Илүүдэл жингүй эртэч монгол аяныг 2022 оны 2 дугаар сарын дугаар сарын 15 ны өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 31 ний өдрийг дуустал зохион байгуулж нийт 15 сумын 80 гаруй байгууллагын 20000 гаруй иргэд хамрагдлаа.	100
			хүний тоо	6000	6100		
			Сумын тоо	15	15		
1.1.1 3	Нийтийн биеийн тамир, спортоор идэвхтэй хичээллэсэн спортод ээлтэй аж ахуйн нэгж байгууллага, сум шалгаруулах	4.0 сая	Спортод ээлтэй байгууллага, сум шалгаруулсан эсэх /тийм үгүй/	-	1	ББТТСорил, бүх нийтийн кросс гүйлт, цахим гимнастрада иргэдийн спортын наадам, нийтийн бүжиг, спорт хамлагуудын дундах 5 төрөлт спортын арга хэмжээ зэрэг үйл ажиллагаанд оролцсон сум, аж ахуйн нэгжийг шалгаруулаад байна.Спортод ээлтэй сумаар Баянжаргалан, Хулд, Луус сум аж ахуйн нэгж байгууллагаар УЦУОШГазар, ЦДСС-ХХК-н, Дэлгэрэх Бүрд ХХК-н тус тус шалгарсан байна.	100
1.1.1 4	Олон улсын стандартад нийцсэн усан бассейн бүхий спортын цогцолбор байгуулах.	УТХО 2000.0 тэр бум	Спортын цогцолборын гүйцэтгэлийн хувь	0	20	Усан бассейн бүхий спорт цогцолборын нийт нэг тэр бум таван зуун тавин нэгэн /1.551.0/ сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэлийг Жи жи ай ХХКомпани гүйцэтгэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 13 хувь Газар шорооны ажил 100 хувь суурийн ажил 90 хувь гадана цахилгаан 60 хувь цутгамал хана 37	100

						хувьтай байна Нийт ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна	
1.1.1 5	Аймгийн Цэнгэлдэх хүрээлэнг ашиглалтад оруулан, спортын талбайг байгуулна.	ОНТ 500.0 сая УТХО 1557.0	Спортын талбайн гадна тохижилт, гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэлийн хувь	85	100	Зуут Констракшин” ХХКомпани 2022 онд талбайн гадна тал үндэсний сурын хараваан талбай байгуулж гэрэлтүүлэгийн ажлыг 100 хувь гүйцэтгэж улсын комисс ажиллан хүлээж аваад байна. Мандал шилтгээн ХХКомпани машины зогсоолын ажлыг 100 хийж гүйцэтгээд байна. Аймгийн ЗДТГазар БТСГазар, БОАЖГазар, спорт холбоодтой хамран	<b>100</b>
Зорилт 2.1	Иргэдийн нас, биеийн онцлогт тохирсон спортын 15 төрлөөр аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	УТ 18.0 сая	Тамирчдын тоо	3000	3500	Аймгийн спортын 17 холбоо 8 клубтэй хамтран, нас насны ангиллаар Бүх ард түмний XV наадам, Үндэсний спортын VII наадмын анхан шатны тэмцээн болон улсын аварга шалгаруулах тэмцээн 6 улсын бүсийн аварга шалгаруулах тэмцээн 2 аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээн зэрэг 70 гаруй уралдаан тэмцээнийг зохион байгуулж, нийт 28500 тамирчид оролцсон байна.	<b>100</b>
2.1.1	Үндэсний спортын наадмын анхан шатны тэмцээнийг орон нутагт зохион байгуулж шалгарсан тамирчдыг шигшээ тэмцээнд оролцуулах	ОНТ 10,0 сая	Үндэсний спортын төрлийн тоо	-	5	Үндэсний спортын наадмын анхан шатны тэмцээнийг спортын 6 төрлөөр орон нутагт амжилттай зохион байгуулсан. Монголын үндэсний спортын 7-р наадмын шигшээ тэмцээнд шагайн харваа, сур, бөх, морьт харваа, уран уургач, бугуйлч, ширээн шагай зэрэг спортын 9 төрлөөр оролцож сурын харваа багаараа мөнгөн медаль, хувийн цуваа харваа мөнгөн медаль, эмнэг сургагч хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлээд байна.	<b>100</b>
2.1.2	“Иргэдийн наадам” биеийн тамирын арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулах	УТ 14.0 сая	Наадамд оролцсон	15	15	Иргэдийн наадам биеийн тамирын арга хэмжээг спортын 5 төрлөөр 15 сумын 17 багийн 480 гаруй тамирчдын дунд амжилттай зохион байгуулсан.	<b>100</b>

			сумдын тоо				
2.1.3	Төрийн албан хаагчдын дунд спортын бага наадам зохион байгуулах	ОНТ 2.0 сая	Оролцсон байгууллагын тоо	10	11	Засаг даргын харьяа агентлагийн дунд сагс, волейбол, теннис, шатар, дартс зэрэг спортын 5 төрлөөр бага наадм зохион байгуулж явууллаа. Тус арга хэмжээнд 22 байгууллага оролцож багийн дүнгээр шилжин явах цом зохион байгуулах эрхийг аймгийн УЦУОШГазар хүлээн аваад байна.	<b>100</b>
2.1.4	Өсвөрийн шигшээ багийн тамирчдын сургалт дасгалжуулалт зохион байгуулж тамирчдын тоог нэмэгдүүлэх	0	Өсвөрийн шигшээ багийн тамирчдын тоо	120	125	Өсвөр үеийн шигшээ багийг спортын 15 төрлөөр байгуулж 156 тамирчны бэлтгэл сургуулилалтыг ханган ажиллаж байна. Улсын аварга шалгаруулах Таеквондогийн тэмцээн болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15 төрлөөр 32 арга хэмжээ зохион байгуулсан байна. Сагсан бөмбөгийн 5х5, 3х3, хөнгөн атлетик, волейбол, уран гимнастик, жүдо,самбо зэрэг улс бүсийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдыг оролцуулаад байна.	<b>100</b>
2.1.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх	УТ 420.0	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /мянга/	450.0	500.0	Боломжийг бүгдэд чуулга уулзалтын хүрээнд зохион байгуулсан спортын арга хэмжээнд оролцсон тамирчдад эд материалын болон санхүүгийн 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	<b>100</b>
2.1.6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэдийг нийтийн биеийн тамир болон спортын үйл ажиллагаанд оролцуулах зорилгоор эрүүл мэндийг нь дэмжих, амьдралын эрүүл хэв маяг төлөвшүүлэх	УТ 500.0	нийтийн биеийн тамир болон спортын арга хэмжээнд оролцон тамирчдын тоо	100	110	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд аймгийн аварга шалгаруулах волейбол, теннис, 100 буудалт даамны тэмцээнийг амжилттай зохион байгуулж алхах, гүйх, дугуй унах зэрэг арга хэмжээнд 120 гаруй тамирчдыг хамруулаад байна . Боломжийг бүгдэд чуулга уулзалтын хүрээнд спортын 4 төрлөөр арга хэмжээнд зохион байгуулсан.	<b>100</b>

2.1.7	Ахмад настныг нийтийн биеийн тамир болон спортын үйл ажиллагаанд хамруулах, эрүүл мэндийг нь дэмжих	УТ 500.0	Зохион байгуулсан арга хэмжээн ий тоо	7	8	Ахмад настны дунд спортын 8 төрлөөр бага наадам, улсын аварга шалгаруулах шатрын тэмцээнийг тус тус зохион байгуулсан.	100
2.1.8	Сагсан бөмбөгийг 3x3 спортын төрлийг орон нутаг дэмжин хөгжүүлэх, сумдын 3x3 сагсан бөмбөгийн хэрэглэл материалыг нэмэгдүүлэх	ОНТ 3.0, сая	Хичээллэгчдийн тоо	4600	4700	2022 онд аймгийн төв Сайнцагаан сумын 7,8,9,5 дугаар багийн нутаг дэвсгэрт 3x3 сагсан бөмбөгийн стандарт 4 задгай талбай барьж байгуулсантай холбоотой 3x3 спортоор хичээллэгчдын тоо нэмэгдэж 5200 гаруй болоод байна.	100
			Төсөл бичих	-	1	3x3 сагсан бөмбөгийн спортыг Дундговь аймагт 2022-2024 онд хөгжүүлэх төлөвлөгөө болон төсөл хөтөлбөр боловсруулан аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барьж батлуулаад байна.	100
2.1.9	Бүх ард түмний XV наадмын анхан шатны тэмцээнийг орон нутагт зохион байгуулж шалгарсан тамирчдыг шигшээ тэмцээнд оролцуулах	ОНТ 10.0, сая	Зохион байгуулсан спортын төрлийн тоо	-	13	Монголын бүх ард түмний спортын наадмын анхан шатны тэмцээнийг аймгийн засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 24 ний өдрийн А/75 тоот захирамжаар аймгийн засаг даргын орлогч М.Анхбаяраар ахлуулсан ажлын хэсэг томилогдож 2022 оны 03 дугаар сарын 15 наас 04 дүгээр сарын 28 ний өдрийг хүртэл хугацаанд спортын 15 төрлөөр амжилттай зохион байгуулсан.	100
Зорилт 2.2	Улсын аварга болон улсын бүсийн аварга шалгаруулах тэмцээн орон нутагт зохион байгуулах арга хэмжээний тоог нэмэгдүүлэх	ОНТ 35.0	Зохион байгуулсан спортын төрөл	-	4	Бадминтон, Жүдо, Хөнгөн атлетик, Таеквондо, Волейбол, шатар, Говийн бүсийн Сумо, Төвийн бүсийн сагсан бөмбөг зэрэг улс, бүсийн чанартай 8 тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.	100
2.2.1	Монгол улсын гавъяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит өсвөр үеийн волейболчдын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	ОНТ 13.0	Зохион байгуулсан эсэх /тийм үгүй 1-0/	1	1	Монгол улсын ууган гавъяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит өсвөр үеийн волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 6 дугаар сарын 23-29 ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.Тэмцээнд 19 аймаг, 8 дүүрэг, клубийн охидын 46, хөвгүүдийн 43 нийт 89 багийн 1200 гаруй тамирчид хурд хүч сорин өрсөлдлөө.	100

2.2.2	Хөнгөн атлетикийн олон төрөлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	ОНТ 10.5 сая	Зохион байгуулсан эсэх /тийм үгүй 1-0/	-	1	Боловсролын тэргүүний ажилтан, Биеийн тамир спортын тэргүүний ажилтан, спортын мастер Р.Дэндэв багшийн нэрэмжит 2022 оны Улсын аварга шалгаруулах хүүхдийн олон төрөлт тэмцээн Эрдэнэдалай суманд суманд 9 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд Дорнод, Хөвсгөл, Өвөрхангай, Увс, Хэнтий, Архангай, Дархан-Уул, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Сайнцагаан зэрэг аймаг, сумдаас ирсэн 10 гаруй багийн 300 гаруй тамирчид оролцлоо. Тус тэмцээнээс Дундговь аймгийн баг тамирчид алтан медаль-2 мөнгөн медаль-3 хүрэл медаль-3 хүртсэн амжилт үзүүлсэн байна.	100
2.2.3	Таеквондогийн улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	ОНТ 15.5. сая	Зохион байгуулсан эсэх /тийм үгүй 1-0/	-	1	Олимпын Таеквондогийн өсвөр үе, залуучуудын УАШТ-2022 тэмцээнийг 6 дугаар сарын 3-5 ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Монголын таеквондогийн холбоо, Дундговь аймгийн Олимпын таеквондогийн холбооноос зохион байгуулсан уг тэмцээнд нийслэл хот, орон нутгаас 30 клубийн 300 гаруй хүүхэд залуучууд хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.	100
2.2.4	Бадминтон сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	ОНТ 5.5 сая	Зохион байгуулсан эсэх /тийм үгүй 1-0/	-	1	Бадминтон сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 2 сарын 25-27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.Тэмцээнд нийт 14 аймаг 4 клубийн 283 тамирчид 4 насны ангилалд /18-29, 30-39, 40-49, 50+/ эрэгтэй, эмэгтэй ганцаарчилсан, эрэгтэй, эмэгтэй хос, холимог хосын төрлүүдэд нийт 20 багц /96 ширхэг/ медалийн төлөө гурван өдрийн турш өрсөлдөж аваргуудаа шалгарууллаа.	100
2.2.5	Жүдо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	ОНТ 10.0 сая	Зохион байгуулсан эсэх	-	1	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир спортын газар, Монголын жүдо бөхийн холбоо хамтран 4 дүгээр сарын 26, 27-ны	100



			/тийм үгүй 1-0/			өдрүүдэд Жүдо бөхийн эрэгтэйчүүдийн 45 дахь удаагийн, эмэгтэйчүүдийн 30 дахь удаагийн 2022 оны насанд хүрэгчдийн Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнийг Дундговь аймагт зохион байгууллаа. Тэмцээнд 22 багийн 200 гаруй тамирчид 14 жинд хурд хүчээ сорин өрсөлдлөө.	
2.2.6	Бага насны Сумо бөхийн бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохин байгуулах	ОНТ 3.5 сая	Зохион байгуулсан эсэх /тийм үгүй 1-0/	-	1	Өсвөрийн сүмо бөхийн говийн бүсийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2022 оны 3 дугаар сарын 19-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд 9-12 насны 90 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.	100
Зорилт 3.1	Байгууллагын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах	0	Санхүүгийн зөрчилгүй ажилласан эсэх /тийм үгүй 1-0/	1	1	Байгууллагын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг бодитой төлөвлөн өр авлага үүсгэлгүй ажиллаж тайланг Биеийн тамир, спортын улсын хороо, аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Гүйцэтгэлийн мэдээг шилэн дансанд хуулийн хугацаанд тухай бүр байршуулсан.	100
3.1.1	Шилэн дансны тухай хуулийг дагуу мэдээ тайланг хуулийн хугацаанд байршуулах иргэд олон нийтийг мэдээллээр хангах	0	Шилэн дансанд байршуулсан мэдээллийн тоо	133	133	Шилэн дансанд төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд байршуулж хэвшээд байна. Нийт 133 мэдээллээс хөрөнгө оруулалт тендер, худалдан авалттай холбоотой 24 мэдээлэл, төсөв гүйцэтгэлтэй холбоотой 22 бусад 87 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж иргэдийг мэдээллээр хангаж ажилласан.	100
3.1.2	Биеийн тамирын спортын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх	УТ 4.5. сая	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая,төг/	4.5	4.6	Сагсан бөмбөг, волейбол, бадминтон зэрэг спортын хэрэглэгдэхүүнийг 4,6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.	100
3.1.3	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл	УТ 600,0 мянган	Сурталчилгаа	10	12	Бадминтон сонирхогчдын Улсын аварга шалгаруулах тэмцээн, Жүдо бөхийн улсын аварга	

	ажиллгаагаа сурталчлах ажлыг нэмэгдүүлэх		хийсэн үйл ажиллагааны тоо			шалгаруулах тэмцээн, Таеквондогийн улсын аварга шалгаруулах тэмцээн, өсвөрийн сүмо бөхийн говийн бүсийн аварга шалгаруулах тэмцээн болон аймгийн аварга шалгаруулах тэмцээн зэрэг 15 удаагийн арга хэмжээг Lave телвиз болон орон нутгийн хэвлэл мэдээллээр сурталчилсан.	100
3.1.4	Гадаадын төсөл хөтөлбөрт төсөл бичих.	-	Төсөл бичсэн эсэх /тийм үгүй 1-0/	-	1	Биеийн тамир, спортын газар Волейбол, Сагсан бөмбөг, Хөл бөмбөг, Волейбол, Дугуй, Бадминтон, ширээний теннис, хөнгөн атлетик, үндэсний бөхөөр хичээллэдэг бага, дунд, ахлах насны хүүхдүүдийг бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж материаллаг баазыг сайжруулах чиглэлээр бичиж сургагч багш Д.Алтантогосоор шалгуулан Төслийг Австрали улсын бичил төслийн хөтөлбөрт хүргүүлсэн.	100
3.1.5	Аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дугаар захирамжийн дагуу спортын өндөр амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагчдын судалгааг гаргаж материалыг НБХ-т хүргүүлэх	-	Амжилт гаргасан тамирчин, дасгалжуулагчдын судалгааг гаргаж хүргүүлсэн эсэх /тийм үгүй 1-0/	1	1	“Монголын бүх ард түмний наадам”, “Үндэсний спортын наадам” улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медальт байранд шалгарсан 141 тамирчны судалгааг гаргаж НБХ-т хүргүүлээд байна.	100
3.1.6	Байгууллагын хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгжийг бүрдүүлнэ.	-	Бүрдүүлсэн хадгаламжийн нэгжийн тоо	31	33	Байгууллагын хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн журмын дагуу аймгийн архивт 8 хагаламжийн нэгж шилжүүлэн ажилласан байна.	100

Зорилт 3.2	Байгууллагын соёлыг нэвтрүүлэх төлөвшүүлэх ажлыг нэмэгдүүлэх	0	Арга хэмжээн Д хамрагдсан албан хаагчдын Хувь	100	100	Байгууллагын уламжлалт соёлыг дээдлэн нийт албан хаагчдын дунд сэтгэл ханамжийн судалгаа авах, уучлах өдөрлөг, гэр бүлийн өдөрлөг зэрэг ажлыг зохион байгуулж явуулсан. Сургалт нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, байгууллагын фэйсбүүк, пээж хуудсыг Засаг даргын тамгын газрын фэйсбүүк, пээж хуудас зэрэгт үйл ажиллагааг суртачилан ажиллаж байна.	100
3.2.1	Ажилтнуудын харилцаа хандлага, ёс зүйн талаар сэтгэл ханамжийн судалгаа авах	УТ 200.2	Судалгаанд хамрагдсан албан хаагчдын тоо	15	15	Нийгмийн баталгаа, байгууллагын соёл, эрүүл мэнд зэрэг сэдвээр нийт 15 албан хаагчаас сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан.	100
3.2.2	Байгууллагын фэйсбүүк, пээж хуудсыг идэвхжүүлэх	ОНТ-500	Хандалтын тоо	50.0	51.0	Байгууллагын фэйсбүүк, пээж хуудсыг Засаг даргын тамгын газрын фэйсбүүк, пээж хуудас болон идэвхтэй үйлажиллагаа явуулж байгаа фэйсбүүк, пээж хуудсанд холбон ажилласан.	100
3.2.3	Хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх, e-mongolia системийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулах	-	e-mongolia системийг ашиглаж байгаа албан хаагчдын тоо.	-	15	Нийт албан хаагчдын гар утас-анд E-Mongolia аппилкейшн суулгаж хэрхэн нэвтрэх ашиглах талаар зөвлөн ажиллаж байна. Мөн тэмцээн уралдааны үед тамирчдын мэдээллийг E-Mongolia аппилкейшин ашиглан шалгаж байна. Иргэний цахим гарын үсэг, үйлчилгээнд нэгдэн үйлчилгээг цахимаар авах боломж бүрдүүлээд байна.	100
3.2.4	Байгууллагын гадна өнгө үзэмжийг сайжруулах сэргээн засварлах	УТ 150.0 сая	Дээврийн засварын ажлын гүйцэтгэ	-	100	Дээврийн засварын ажлыг тендерт "Мандал өргөө голомт" ХХКомпани шалгарч гэрээний дагуу ажлыг 2022 оны 04 дүгээр сард 100 хувь гүйцэтгээд байна.	100

			лийн хувь				
3.2.5	Байгууллагын хашаанд төрөлжсөн хогийн сав байршуулах	ОНТ 1,500.0 сая	Хогийн савны тоо	-	2	Байгууллагын хашаанд 2 ширхэг төрөлжсөн хогийн сав байршуулж ахуйн хог хаягдлыг ялган ангилж хоёр дахь түүхий эдийг дахин ашиглагдаж байна.	100
3.2.6	Байгууллагын хашаа болон хуваарьт газарт мод тарих ажлыг зохион байгуулах	ОНТ 1,0 сая	Тарьсан модны тоо	160	200	Байгууллагын хашаанд цэцгийн мандал байгуулж, хуваарьт газар тарсан модны ургаагүй суулгацыг солих, цэнгэлдэх хүрээлэнгийн ойр орчимд зураг төсвийн дагуу спорт холбоодтой хамтран 6000 ширхэг мод тариад байна. Модны ургалт 80 хувьтай байна.	100
3.2.7	Байгууллагын гадна хаягийн шинэчлэн солих	ОНТ 1,0 сая	Хаяг хийлгэсэн эсэх /тийм үгүй/	-	1	Байгууллагын гадна хаягийг шинэчлэн сольж Англи, монгол, уйгуржан бичиг хосолсон гэрэлтүүлэгтэй хаяг хийлгэж байршуулсан.	100
Зор илт 3.3	Хүний хөгжлийг дэмжих жилийн хүрээнд албан хаагчдыг чадавхжуулах	УТ 2.0сая	Төлөвлөгөө боловсруулан ажиллах /тийм үгүй 1-0/	15	15	Хүний хөгжлийг дэмжих жилийн ажлын хүрээнд төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
3.3.1	Биеийн тамир, спортын чиглэлээр ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх	ОНТ 1,500,0 сая	Хамтран ажилласан байгууллагын тоо	2	3	Нийслэлийн Налайх дүүрийн БТСХороо, Өмнөговь аймгийн БТСГ, Уурхайчин клуб, Хилчин клубтэй хамтран ажиллаж харилцан туршлага солилцож ажиллаж байна.	100
3.3.2	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлж байгууллагын хаяг, нэрийн хуудас, өрөөний хаягийг хос бичгээр хэвлсэн байх	ОНТ-2,0 сая	Хэвлэлийн тоо	3	8	Албан өрөө, байгууллагын гадна хаяг, зэрэг 8 хэвлэл материал монгол бичгээр хэвлүүлэн хаягжуулаад байна. Албан хаагчдын гар утсанд монгол бичиг аппликейшн болон компьютерт	100

						монгол бичгийн keyboard суулгаж хэрэглээндээ нэвтрүүлэх зорилготой ажиллаж байна.	
3.3.3	Аймгийн Биеийн тамирын багш нарт спортын дүрмийн сургалт явуулж шүүгч бэлтгэх	ОНТ 2.5. сая	Бэлтгэгдсэн шүүгч нарын тоо	22	12	Бадминтон, сагсан бөмбөг ,хөл бөмбөг, Пара бочи Таеквондогийн шүүгчийн сургалтад нийт 43 биеийн тамирын багш нарыг хамруулан зохион байгуулсан.	<b>100</b>
			Сургалт явуулсан спортын төрөлийн тоо	1	4	Бадминтон, сагсан бөмбөг ,хөл бөмбөг, Пара бочи, Таеквондогийн холбоотой хамтран спортын 5 төрлөөр шүүгчийн сургалт зохион байгуулсан.	<b>100</b>
<b>Нийт</b>							<b>100</b>

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

№	Сургалтын нэр	Шалгуур үзүүлэлт	Суурь Түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
Хууль эрх зүйн сургалт						
1	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга сэдвээр сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	15	15	Үйлдвэрчний эвлэлийн дарга Мөнхчулууныг урьж хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулга сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад 15 албан хаагч бүрэн хамрагдсан.	100
2	Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн сургалт.	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	15	15	Аймгийн архивын тасгийн дарга Т.Уранбайгаль Биеийн тамир, спортын газрын албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлт сургалт явуулсан. Сургалтад 15 албан хаагч бүрэн хамрагдсан.	100
3	Нийгмийн даатгалын тухай хууль	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	10	15	Нийгмийн даатгалын хэлтсийн сургалт хариуцсан байцаагч Э.Алтантулга Биеийн тамир, спортын газрын албан хаагчдад хуулийн сургалт хийлээ. Сургалтад 15 албан хаагч бүрэн хамрагдсан.	100
4	Татварын тухай хууль	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	15	15	Аймгийн татварын хэлтсийн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Замэндий Биеийн тамир, спортын газрын албан хаагчдад хуулийн сургалт хийлээ. Сургалтад 15 албан хаагч бүрэн хамрагдсан.	100
Ажлын байран дээр дадлагжуулах сургалт						
1	Аймгийн засаг даргын тамгын газар, Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад албан хаагчдыг хамруулах.	Сургалтад хамрагдсан албан хаагчдын хувь	100	100	Холбогдох дээд байгууллагаас зохион байгуулж явуулсан цахим болон танхимын сургалтад албан хаагчдыг 100 хувь хамруулсан.	100
2	Компьютерын ахисан түвшний сургалтыг зохион байгуулах.	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	-	15	Биеийн тамир, спортын газрын сүлжээний инженер Б.Баттүвшин компьютерын ахисан түвшний сургалтыг	100

					нийт албан хаагчдад явуулсан. Сургалтад 15 албан хаагч хамрагдсан.	
3	Монгол хэл, бичгийн дүрэм сэдэвт ажлын байрны сургалт зохион байгуулах.	Батламж авсан албан хаагчдын тоо	14	15	Цэгц билиг сургуулийн багш М.Ганбаганатай гэрээ байгуулан гэрээний дагуу 40 цагийн сургалт авлаа сургалтад 15 албан хаагч хамрагдсан.	100
4	Жендерийн болон ажлын байран дахь билгийн болон дарамт сэдэвт сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	15	15	Аймгийн засаг даргын тамгын газар, БТСҮХ-оос зохион байгуулсан Жендерийн тэгш байдал, ажлын байран дахь бэлгийн дарамт сэдэвт 3 удаагийн суралтад 15 албан хаагчид хамрагдсан.	100
Нийт					100	

**БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН 2022 АЖИЛЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН**

№	Сургалтын нэр	Шалгуур үзүүлэлт	Суурь Түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
<b>Ажлын байран дээр дадлагжуулах сургалт</b>						
1	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх албан хаагчид үр дүн, ур чадварын нэмэгдэл олгох	Урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	15	15	Төрийн албаны тухай хуулийг даган гарсан журмын дагуу 15 албан хаагчдад шагнал, урамшуулал олгосон.	100
2	Ахмад настанд ахмадын баяр болон цагаан сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлэх	Хүндэтгэл үзүүлсэн ахмад настны тоо	13	13	Байгууллагын харъяаны 13 ахмад настанд цагаан сар шинийн баяр болон ахмад настны баярын өдрийг угтаж хүндэтгэл үзүүлсэн	100
3	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Үзлэгт хамрагдсан албан хаагчдын тоо	-	15	Байгууллагын 15 албан хаагчийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан.	100
4	Албан хаагчдад байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгт хамрагдсан албан хаагчдын тоо	5	10	Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 12 албан хаагчид цалинтай чөлөө олгосон.	100
5	Албан хаагчдын эрүүл мэндийг нь дэмжиж витаминжуулах арга хэмжээ зохион байгуулах	Арга хэмжээнд хамрагдсан албан хаагчдын тоо	14	15	Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу байгууллагын 15 албан хаагчийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан.	100
6	Албан хаагчдын хүүхдэд, хүүхдийн эрхийг хамгаалах өдөр хүндэтгэл үзүүлэх	Хүндэтгэл үзүүлсэн хүүхдийн тоо	25	25	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр албан хаагчдын 25 хүүхдэд хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.	100
<b>Нийт</b>					<b>100</b>	